

# 2022-2023 онд шинээр нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжүүд:

2022.11.18-ны өдөр Өмнөговь аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газрын санаачилга, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрүүл мэндийн төслийн хүрээнд хүүхдийн ходоодны дуранг БОЭТөвд, хүчилтөрөгчийн хамгийн сүүлийн үеийн иж бүрэн барокамерыг Өнө-орших ӨЭМТөвд хүлээлгэн өгсөн.



2022 оны 11-р сард БОЭТөвд чих хамар хоолойн үзлэгийн зориулалтын тоноглогдсон ширээ, сандал дагалдах багаж, дурангуудыг “Биомедикал” ХХК гэрээнд заасан хугацаанд нийлүүлж ашиглалтад оруулсан.



# 2022 он

БОЭТ-ийн Хүүхдийн тасагт орон нутгийн төсвөөр нийт 19 сая төгрөгийн өртөг бүхий 11 нэр төрлийн 24 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. /Эх хүүхдийн хөтөлбөр/

Манлай сумын ЭМТ-д 96,4 сая төгрөгийн ЭХО аппарат дагалдах хэрэгслийн хамт “Медимпекс” ХХК нийлүүлсэн.



# 2022 он

Цогтцэций сумын ЭМТ-д нийт 50 сая төгрөгийн гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

2022 онд Номгон СЭМТ-д орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Чоно гол трейд” ХХК-тай гэрээ байгуулан 65 сая төгрөг бүхий 19 нэр төрлийн 21 багаж, тоног төхөөрөмж, мөн 39,900,000 төгрөгийн өртөг бүхий хэт авиан аппарат хүлээлгэн өгсөн.



# 2023 он

Хавдрыг эрт илрүүлэх ажлын хүрээнд: Нийт 110,000,000 төгрөгийн төсөв бүхий 4 ширхэг кольпоскопи аппаратыг БОЭТ, Гурвантэс, Цогтцэций, Шимбилэг ЭМБ-уудад хүлээлгэн өгсөн.


БОЭТ-д харшлын кабинетын тохижилт, тоног төхөөрөмж худалдаж авах ажлын хүрээнд: “Санаа мед” ХХК-тай гэрээ хийж 2023 оны 10-р сарын 11-нд хүлээлгэж өгсөн.



# 2023 он

Өнө-орших ӨЭМТ, Эрүүл мэндийн газарт тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангах ажлыг “Санаа мед” ХХК-тай гэрээ байгуулан 7-р сарын 10-нд нийт 76,000,000 төгрөгийн төсөв бүхий шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүрэн нийлүүлж хяналтын камер, архивын шүүгээг суурилуулсан.

Орон нутгийн 2,8 тэрбумын төсвөөр БОЭТ-д “Си Ай Ти” ХХК-тай гэрээ байгуулан сүүлийн үеийн Canon брэндийн 160 зүслэгт компьютер томографыг 2023 оны 10-р сарын 13-нд бүрэн суурилуулж хүлээлгэн өгсөн. Ашиглалтад орсноос хойш 257 хүнд оношилгоо шинжилгээ хийснээс 27 нь тодосгогчтой хийгдсэн байна.



# 2023 ОН

Орон нутгийн 349,700,000 төгрөгийн төсвөөр эмчилгээ оношилгоонд шаардлагатай фиброскан тоног төхөөрөмжөөр хангах ажилд “Сүвэн-уул” ХХК шалгарч 7-р сарын 23-нд ашиглалтын сургалт хийж БОЭТ-д хүлээлгэн өгсөн. Суурилуулагдсанаас хойш нийт 17 хүн оношилгоонд хамрагдсан байна.

БОЭТ-д унтуулгын аппаратын иж бүрдлийг “Биомед” ХХК-тай 56,980,000 төгрөгийн гэрээ байгуулан 2023 оны 6-р сард ашиглалтын сургалтыг хийж ашиглалтад оруулсан. Мөн нүдний оношилгооны тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр “Ариун мед” трейд шалгарч 40,660,000 төгрөгийн гэрээ хийсэн. Гэрээний хугацаанд буюу 6- сард нийлүүлж ашиглалтад өгсөн.



# 2023 он

Эрт илрүүлгийн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд: “Ай Эм Эс инженеринг” ХХК шалгарч 49,000,000 сая төгрөгийн төсөв бүхий ходоодны уян дурангийн ариутгалын аппаратыг БОЭТ-ийн дурангийн нэгжид 5-р сарын 15-нд нийлүүлж байнгын ашиглалтад оруулсан

БОЭТ-ийг Элэгний мэс заслын багаж хэрэгслээр хангах ажлын тендер зарлагдан “Л2” ХХК шалгарч 49,928,000 төгрөгийн гэрээ хийж 2023 оны 4-р сарын 10-нд БОЭТ-ын мэс заслын тасагт нийлүүлж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Ингэснээр орон нутгийн хэмжээнд өмнө нь хийгдэх боломжгүй байсан элэгний шалтгаант төрөл бүрийн мэс заслыг амжилттай явуулах боломж бүрдсэн.



Сумын ЭМТ-үүдийн эмчилгээ оношилгоонд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 550 сая төгрөгийн төсөв бүхийн 13 нэр төрлийн 37 ширхэг эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжүүдийг “Мед буян” ХХК гэрээ хийн 2023 оны 12-р сард нийлүүлж ашиглалтын сургалтыг хийн хүлээлгэн өгсөн.





Орон нутгийн төсвөөр 48,726,000 төгрөгийн хиймэл оюун ухааны тоног төхөөрөмжийг “Сүвэн-уул” ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 6-р сарын 23-нд ашиглалтын сургалтыг хийж БОЭТ-д хүлээлгэн өгсөн. Ашиглалтад орсноос хойш 162 хүн оношилгоонд орсон байна.

